



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн / улсын төсөв / 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/262/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Т.Одсүрэн Утас: 70362442 Цахим хаяг: <a href="mailto:odsurent@audit.gov.mn">odsurent@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудитын санал, дүгнэлт .....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-7
3.Аудитын тайлан.....	8
3.1. Ерөнхий зүйл.....	8
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8-9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4. Материаллаг байдал .....	9
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8. Аудитын гол асуудал .....	11
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11-12
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт .....	12-13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

---

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>НА</b>	Нотлох аудит
<b>СТА</b>	Санхүүгийн тайлангийн аудит
<b>СЭА</b>	Сэлэнгэ аймаг
<b>УСНББОУС</b>	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
<b>ХХҮГ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
<b>ХХҮЕГ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
<b>МХГ</b>	Мэргэжлийн хяналтын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.11 № СЭА-2022/262-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /улсын төсөв/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /улсын төсөв/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		4317143098
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		МКУА0065 9055436
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		
31210	Төгрөг		
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
33500	Бусад авлага		
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
35100	Түүхий эд материал		
35400	Хангамжийн материал		
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>		
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
39200	Биет хөрөнгө		
39300	Биет бус хөрөнгө		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		
51	Засгийн газрын хувь оролцоо		
51200	Хуримтлагдсан үр дүн		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,662,478,522.52</b>	<b>5,253,465,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,829,545.52</b>	<b>780,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,829,545.52</b>	<b>780,500.00</b>
120002	Хүүгийн орлого	6,636,195.52	-
120009	Бусад орлого	193,350.00	780,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,655,648,977.00</b>	<b>5,252,685,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>14,655,648,977.00</b>	<b>5,252,685,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,655,648,977.00	5,252,685,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,662,478,522.52</b>	<b>5,253,465,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,662,478,522.52</b>	<b>5,253,465,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,083,900.00</b>	<b>1,761,550.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,083,900.00</b>	<b>1,761,550.00</b>

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,083,900.00	1,761,550.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,656,394,622.52</b>	<b>5,251,703,950.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,415,018,852.00</b>	<b>5,146,943,276.50</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,415,018,852.00	5,146,943,276.50
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>241,375,770.52</b>	<b>104,760,673.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	241,375,770.52	104,760,673.50
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	=	=

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
5	Тайлант үеийн үр дүн				
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
7	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл				

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>14,662,478,522.52</b>	<b>5,253,465,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,829,545.52</b>	<b>780,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,829,545.52</b>	<b>780,500.00</b>
120002	Хүүгийн орлого	6,636,195.52	-
120009	Бусад орлого	193,350.00	780,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,655,648,977.00</b>	<b>5,252,685,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>14,655,648,977.00</b>	<b>5,252,685,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,655,648,977.00	5,252,685,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>14,662,478,522.52</b>	<b>5,253,465,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,662,478,522.52</b>	<b>5,253,465,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,083,900.00</b>	<b>1,761,550.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,083,900.00</b>	<b>1,761,550.00</b>
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,083,900.00	1,761,550.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,656,394,622.52	5,251,703,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,415,018,852.00	5,146,943,276.50
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,415,018,852.00	5,146,943,276.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	241,375,770.52	104,760,673.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	241,375,770.52	104,760,673.50
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,252,685,000.00	5,148,704,826.50	103,980,173.50	98.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,252,685,000.00	5,148,704,826.50	103,980,173.50	98.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,870,000.00	1,761,550.00	1,108,450.00	61.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,870,000.00	1,761,550.00	1,108,450.00	61.38
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,870,000.00	1,761,550.00	1,108,450.00	61.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,249,815,000.00	5,146,943,276.50	102,871,723.50	98.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,249,815,000.00	5,146,943,276.50	102,871,723.50	98.04
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,249,815,000.00	5,146,943,276.50	102,871,723.50	98.04
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,252,685,000.00</b>	<b>5,148,704,826.50</b>	<b>103,980,173.50</b>	<b>98.02</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,252,685,000.00	5,148,704,826.50	103,980,173.50	98.02
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,252,685,000.00	5,148,704,826.50	103,980,173.50	98.02
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /Улсын төсөв/ *Ицашид Халамжийн сан гэх* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн “Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа, Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдэл болон байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд асаргааны тэтгэмж олгох гэрээ”-тэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 13-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын “Халамжийн сан”-гийн үйл ажиллагааны зорилго, зорилт, чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгож, амьжиргааны түвшинг дээшлүүлэх.
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Засгийн газрын 2021 оны 362 дугаар тушаалаар “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам” шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Халамжийн сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус сангийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, МХЕГ-ын даргын 2021 оны 0/71 дүгээр удирдамжийн хүрээнд “Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд өрх, иргэдийг хамруулсан байдал, зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д урьдчилан сэргийлэх шалгалтыг аймгийн МХГ-аас гүйцэтгэж, дээрх үйл ажиллагааг хуулийн хүрээнд, үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн орлого болох 5,252,685.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 52,526.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 36,768.8 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халамжийн сангийн санхүүгийн тайланг УСНББОУС болон түүнд нийцүүлэн баталсан хууль, дүрэм, журмын хүрээнд нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн гаргасан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд “*Нийгмийн халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан байна*” гэж заасны дагуу халамжийн сангийн хөрөнгө нь зөвхөн мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэж байна. Өөрөөр хэлбэл Халамжийн сангийн санхүүгийн тайланд бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг хөрөнгийн бусад хэлбэрүүд тусгагдаагүй байна.

Тайлант онд нийгмийн халамжийн үйлчилгээг Нийгмийн халамжийн нэгдсэн цахим системд шилжүүлж, ХХҮЕГ-аас санхүүжилтийг шууд олгож эхэлсэнтэй холбоотойгоор Халамжийн сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого, зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 9,409,013.0 мянган төгрөгөөр буюу 64.2 хувиар буурч, 5,252,685.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг тус бүр 27,275,421.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 16,145,820.5 мянган төгрөгөөр бууруулж 11,129,601.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг 2021 оны 12-р сард тодотгож, 5,876,916.0 мянган төгрөгөөр бууруулан 5,252,685.0 мянган төгрөг болгосон нь халамж, тэтгэврийн олголтод “Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор насны хишиг, цалинтай ээж, жирэмсэн эхийн тэтгэмж, эхийн алдар одонтой ээжүүдийн мөнгөн тусламжийг ХХҮЕГ-аас шууд олгох болсон болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх иргэдийн тоо буурсан зэргээс шалтгаалсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,252,685.0 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр эцэслэн баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,252,685.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, өмнөх оны олголтоос буцаан төвлөрүүлсэн 780.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн тэтгэвэр тэтгэмжийн зардалд 5,146,943.3 мянган төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардалд 1,761.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 104,760.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,148,704.8 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмжийн зардал 103,980.2 мянган төгрөгөөр хэмнэгдэж, улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.



### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

**3.7.1** Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бүх сумдад хүрч ажиллах боломжгүй учир Алтанбулаг, Баруунбүрэн, Мандал, Сант, Сайхан, Сүхбаатар, Жавхлант, Орхонтуул, Шаамар зэрэг 9 сумын хөдөлмөрийн чадвар алдалтын /хугацаатай/ тэтгэвэр, байнгын асаргааны тэтгэмжийн хувийн хэрэгт түүврийн арга ашиглан тулган баталгаажуулалт хийсэн болно.

**3.7.2** Санхүүгийн тайлангийн аудитад тус халамжийн сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудлыг бүрэн хамруулсан бөгөөд халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн хувийн хэрэг, тэтгэвэр, тэтгэмж тогтоолтыг иж бүрэн тулган баталгаажуулах боломжгүй тул цаашид гүйцэтгэл, нийцлийн аудитаар авч үзэх шаардлагатай юм.

**3.7.3** Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан өрх, иргэний мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлж байгаатай холбогдуулан халамжийн үйлчилгээ олгох шалгуурт заасан, бүрдүүлэх баримт бичгийг мэдээллийн санд иж бүрэн оруулаагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Халамжийн сангийн мэдээлбэл зохих 20 төрлийн 148 мэдээлэл байршуулахаас 146 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол, 1 мэдээлэл / тухайн жилийн төсөвт орсон, нэмэлт, өөрчлөлт (тухай бүр) 10, 12 сард/-ийг 2 удаа хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээлэл хоцроон байршуулсан зөрчлийг арилгуулах зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитаар тус халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж байгаа 17 сумын иргэдийн хувийн хэрэг, тэдгээрийн тогтоолттой холбоотой асуудлыг дараагийн аудитаар нарийвчлан тулган баталгаажуулах шаардлагатай.



## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж мөнгөн тусламжид хамрагдах хүсэлт гаргасан өрх, иргэний баримт бичиг, амьдралын нөхцөлийг судлан үзэж, тэдгээрийг холбогдох нийгмийн халамжид хамруулах эсэхийг шийдвэрлэх сум тосгодын “Амьжиргаа дэмжих зөвлөл”-ийн хурлаар хэлэлцсэн асуудлыг Цагааннуур сумаас бусад сумдууд бүх гишүүдийн бус зөвхөн зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын гарын үсгээр баталгаажуулж байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Амьжиргаа дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 3.4-т “Зөвлөлийн шийдвэр нь хурлын тэмдэглэлд тусгаагдах бөгөөд шийдвэрийн хэсгийг хуралдаанд оролцсон гишүүдийн гарын үсэг, тухайн сум, хорооны Засаг даргын тамгаар баталгаажуулна.” гэж заасны дагуу хуралд оролцсон гишүүдээр баталгаажуулж байх.

#### 2. Тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдэлтэй холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур, үзүүлэлтийг үндэслэн сум хорооны “Амьжиргаа дэмжих зөвлөл”-өөр хэлэлцүүлсэн шийдвэрийг тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэгт хавсаргаагүй байна.
- 2.2. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 2.2 дэх “...Сум хорооны нийгмийн ажилтан нь Амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрийг холбогдох баримт бичгийн хамт ажлын 5 хоногт багтаан аймаг, ... нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.”, 2.4 дэх “Нийгмийн халамж үйлчилгээний байгууллага нь энэхүү журмын 2.2, 2.3-т заасан баримт бичгийг ажлын 5 хоногт багтаан хянан үзэж, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах иргэнд хувийн хэрэг нээн, ... хувийн хэргийг баталгаажуулна” гэсэн заалтын дагуу Халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, авч байгаа иргэдийн хувийн хэрэгт амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрийг хавсаргаж байх.

#### 3. Гэрээний биелэлттэй холбоотой асуудал

- 3.1. Илрүүлэлт: Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд асаргааны тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зарим

гэрээний хугацааг тодорхойлоогүй, сунгалтыг хийгээгүй, гэрээг баталгаажуулалгүйгээр хувийн хэрэгт хавсаргасан байна.

- 3.2. **Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 2.10-т “Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.3, 13.2.4-т заасан иргэнд тэтгэмж олгохдоо сум, хорооны нийгмийн ажилтан нь асрамжилж байгаа болон асруулагч иргэнтэй “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах тухай гэрээ” байгуулна”, 2.12-т “Энэхүү журмын 2.9, 2.10-т заасан гэрээний загварыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална”, ХХҮГ-ын даргын 2012 оны 162 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд асрах тухай гэрээ”-ний 2.3-т “Гэрээг сумын ерөнхий эмч, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын комиссын шийдвэрт заасан хугацаагаар, ХХҮГ-ын үнэлгээний дүн, гэрээг сунгах зөвшөөрөл, амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухай бүр сунгана” гэж заасны тус тус мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Халамжийн сан / улсын төсөв /	3									3	